



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 19 (544)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Барилгын тухай (шинэчилсэн найруулга)*
- *Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Сонгуулийн хорооны гишүүний ёс зүйн дүрэм батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2008 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2008 оны тавдугаар сарын 23

№19 (544)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

262.	Барилгын тухай (шинэчилсэн найруулга)	438
263.	Барилгын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	448
264.	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	448
265.	Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	448
266.	Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	454
267.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	454
268.	Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	455
269.	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	455
270.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	455
271.	Орон нутгийн хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	456
272.	Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	456
273.	Намын гишүүнээс түдгэлзвэл зохих албан тушаалын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай	456
274.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай	457
275.	"Эх нялхсын эрдэм шинжилгээний төвийн үйл ажиллагааг сайжруулах төсөл"-ийн зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай	457
276.	"Дарханы дулааны цахилгаан станцын турбинийг шинэчлэх төсөл"-ийн зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай	457
277.	Ялтан шилжүүлэх тухай гэрээ соёрхон батлах тухай	457
278.	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	458
279.	Орон нутгийн хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	458
280.	Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	458
281.	Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	459
282.	Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	459
283.	Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	459
284.	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	460



Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

285.	Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх тухай	Дугаар 24	460
286.	Сонгуулийн хорооны гишүүний ёс зүйн дүрэм батлах тухай	Дугаар 25	460
287.	Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай	Дугаар 26	462
288.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 27	462
289.	Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгууль товлон зарлах тухай	Дугаар 29	462
290.	Сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай	Дугаар 31	463
291.	Н.Лувсанжавыг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай	Дугаар 36	463
292.	Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох тухай	Дугаар 37	463
293.	Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай	Дугаар 40	463
294.	Засгийн газарт эрх олгох тухай	Дугаар 42	464

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

295.	Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах тухай	Дугаар 93	464
------	---------------------------------------------------	-----------	-----

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

296.	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4.3 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай	Дугаар 06	466
------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	-----------	-----

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 02 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

БАРИЛГЫН ТУХАЙ

/шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

Нийтлэг үндэслэл

2.2 Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

1.1.Энэ хуулийн зорилт нь барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын материал үйлдвэрлэх, барилгын ажил гүйцэтгэх, ашиглах, техникийн хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

3.1 Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

2 дугаар зүйл. Барилгын тухай хууль тогтоомж

3.1.1."зураг төсөл" гэж барилга байгууламжийг барих, засвар, өргөтгөл, шинэчлэл хийхэд шаардагдах техник, эдийн засгийн үндэслэл, техникийн болон ажлын зураг, инженер-геологийн судалгааны дүгнэлт, геодезийн

2.1.Барилгын тухай хууль тогтоомж нь "Үндсэн хууль", "Иргэний хууль", энэ хууль болон

¹ Үндсэн хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

² Иргэний хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

зураглал, барилга байгууламжийн өртгийн нэгдсэн төсвийг;

3.1.2. "Барилгын ажил" гэж бүх төрлийн барилга байгууламжийг барих, өргөтгөл, шинэчлэл, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулах үйл ажиллагааг;

3.1.3. "Барилгын материалын үйлдвэрлэл" гэж барилгын материалын эрдэс, түүхий эд олборлох, материал, бүтээц, эдлэхүүн үйлдвэрлэхийг;

3.1.4. "Барилга байгууламж" гэж барилгын норм, дүрмийн дагуу боловсруулж магадлал хийгдсэн зураг төслөөр тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн барьсан орон сууц, олон нийт, иргэн болон үйлдвэрийн барилга, эрчим хүч, холбоо, зам гүүр, ус суваг, далан хаалт зэрэг байгууламж, инженерийн шугам сүлжээг;

3.1.5. "Барилгын норм, нормативын баримт бичиг" гэж барилга байгууламжид мөрдөх нийтлэг шаардлага зарчмыг агуулсан барилгын норм, дүрэм, стандарт, цомог, заавар, журмыг;

3.1.6. "Барилгын чанарын баталгаат хугацаа" гэж барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авснаас хойш түүний чанар, аюулгүй байдлыг барилгын гүйцэтгэгч хариуцах хугацааг;

3.1.7. "Барилгын техникийн нөхцөл" гэж барилга байгууламжийг дулаан, уур, цэвэр, бохир ус, цахилгаан, холбоожуулалт, радио, дохиоллын эх үүсвэрт холбох тухай эрх бүхий хуулийн этгээдээс гаргах шийдвэрийг;

3.1.8. "Барилгын зураг төслийн магадлал" /цаашид "магадлал" гэх/ гэж барилгын зураг төслийн техник, эдийн засгийн үндэслэл, архитектур, хот төлөвлөлт, үндсэн бүтээцийн бат бөх, инженерийн хангамжийн техникийн шийдэл, эрүүл ахуй, галын аюулгүй байдал, хүрээлэн байгаа орчин, байгалийн баялгийг зохистой ашиглах, үйлдвэрлэлийн технологийн сонголт нь барилгын норм, дүрэм, стандартын шаардлагыг хэрхэн хангасныг тогтоож, мэргэжлийн дүгнэлт гаргах ажиллагааг;

3.1.9. "Зөвлөх үйлчилгээ" гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль¹-ийн 5.1.15-д заасныг;

3.1.10. "Өргөх байгууламж" гэж босоо, хэвтээ чиглэлд хүн, ачаа өргөх, тээвэрлэх зориулалттай тоног төхөөрөмжийг;

3.1.11. "Барилгын орчны тохижилт" гэж тухайн барилгад олгосон газарт барилгажилт, төлөвлөлтийн нормын дагуу төлөвлөсөн мод, бут, сөөг зэрэг ногоон байгууламж, зам, тээврийн хэрэгслийн зогсоол, оршин суугчдын амрах болон хүүхдийн тоглоомын талбай, гэрэлтүүлгийг;

3.1.12. "Барилгын захиалагч" гэж хөрөнгө оруулагчийг итгэмжлэлээр төлөөлж зураг төсөл боловсруулах, материал бэлтгэн нийлүүлэх, барилгын ажлын үе шат, гүйцэтгэлд хяналт тавих, тухайн барилгыг хүлээн авах ажлыг зохион байгуулах үүрэг хүлээсэн мэргэжлийн хүн, хуулийн этгээдийг;

3.1.13. "Барилгын хөрөнгө оруулагч" гэж барилга байгууламжийг барихад шаардагдах хөрөнгийг санхүүжүүлсэн иргэн, хуулийн этгээдийг;

3.1.14. "Үе шатны ажил" гэж барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, ашиглалтад оруулах үйл ажиллагаа тус бүрийн технологийн дарааллын хэсгүүдийг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Барилгын талаархи төрийн байгууллагын бүрэн эрх

4 дүгээр зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

4.1. Улсын Их Хурал барилгын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.1.1. Барилгын салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох, барилгын тухай хууль тогтоомжийг батлах;

4.1.2. Барилгын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

4.1.3. тусгай хамгаалалттай газар нутаг дахь эрдэс, түүхий эдийг барилгын материалын үйлдвэрлэлд ашиглах асуудлыг Газрын тухай⁴, Ашигт малтмалын тухай⁵ хуульд заасны дагуу шийдвэрлэх;

4.1.4. хуульд заасан бусад бүрэн эрх.

¹ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2005 оны 48 дугаарт нийтлэгдсэн.

⁴ Газрын тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 27 дугаарт нийтлэгдсэн.

⁵ Ашигт малтмалын тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2006 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

5 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

5.1. Засгийн газар барилгын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.1. Барилгын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

5.1.2. Барилгын салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого боловсруулах;

5.1.3. Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах болон барилгын ашиглалтын дүрмийг батлаж, мөрдүүлэх;

5.1.4. Барилга захиалагчийн дүрмийг батлах;

5.1.5. Барилгын зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийх, барилгын үе шатны ажилд хяналт тавих, ашиглалтад оруулах хүрээнд зөвлөх үйлчилгээ үзүүлэх дүрмийг батлах;

5.1.6. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм батлах;

5.1.7. Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоо, барилгын нэгж талбайн төсөвт өртөг, төсвийн жишиг үнэлгээ, үнийн индексийг батлах, зарлах.

6 дугаар зүйл. Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

6.1. Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага барилгын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1. Барилгын талаархи төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;

6.1.2. Барилгын норм, дүрэм батлах, стандарт хянах, мөрдүүлэх;

6.1.3. Барилгын норм, норматив боловсруулах санг бүрдүүлэх, зарцуулах журмыг батлах;

6.1.4. Барилгын салбарт шударга өрсөлдөөний орчныг бүрдүүлэх;

6.1.5. салбарын ажилтны давтан сургалт, мэргэжлийн эзрэг олгох дүрмийг батлах;

6.1.6. барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх,

материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих, үйлчилгээний хөлс тогтоох;

6.1.7. инженерийн мэргэжлийн төрлөөр орон тооны бус, мэргэжлийн зөвлөл ажиллуулах дүрэм батлах;

6.1.8. улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах;

6.1.9. орон нутаг дахь хот байгуулалт, барилга захиалагчийн албыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

6.1.10. барилгын салбарын шинжлэх ухаан, техник, технологийн болон барилгын механикжуулалтын бодлогыг хэрэгжүүлэх;

6.1.11. шаардлагатай гэж үзвэл хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилт, газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл олголт, барилга байгууламжийн чанар, паспортжуулалт, бүртгэлийн асуудлаар аймаг, нийслэлийн Засаг даргын тайланг хэлэлцэх.

6.2. Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.2.1. барилгын тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;

6.2.2. барилгын норм, дүрэм, барилгын төсвийн жишиг үнэлгээ, үнийн индекс, стандарт боловсруулах ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх;

6.2.3. барилга байгууламжийн зураг төсөл зохиогч, барилгын ажил гүйцэтгэгч, барилгын материал үйлдвэрлэгчийн бүртгэл хөтлөх;

6.2.4. улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах барилгын ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгогчийг төлөслөн оролцох;

6.2.5. барилгын норм, норматив боловсруулах сан бүрдүүлэх, зарцуулах үйл ажиллагааг зохион байгуулах;

6.2.6. барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх

байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох нэг цэгийн үйлчилгээг зохион байгуулах;

6.2.7. барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох, барилга байгууламжийг ашиглалтад оруулах үйл ажиллагааг зохион байгуулах;

6.2.8. барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх иргэн, хуулийн этгээдийг өрсөлдөөний журмаар сонгох;

6.2.9. магадлал хийх ажлыг зохион байгуулах;

6.2.10. инженер-техникийн ажилтны мэргэжлийг тасралтгүй дээшлүүлэн зэрэг олгож, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хариуцлагын болон сургалтын тогтолцоо бүрдүүлэх, сургалтыг боловсронгуй болгох ажлыг зохион байгуулах;

6.2.11. барилгын мэдээллийн сан бүрдүүлэн сүлжээ байгуулж, түүний байнгын ажиллагааг эрхлэх.

7 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бүрэн эрх

7.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал барилгын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1. барилгын тухай хууль тогтоомж, эрх зүйн акт болон бүрэн эрхийн хүрээнд гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих;

7.1.2. барилга байгууламж барих газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл нь хууль тогтоомж, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэхийг хянаж, Засаг даргын тайланг хэлэлцэх.

7.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга барилгын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.2.1. барилгын талаархи төрийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

7.2.2. барилга байгууламж барих, өргөтгөхөд зориулан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулах тухай асуудлыг газрын тухай хууль тогтоомж, хот,

тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг үндэслэн шийдвэрлэх;

7.2.3. барилгын тухай хууль тогтоомж, норм, дүрэм, стандартын шаардлагыг хэрэгжүүлэх, газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл олгоход нэг цэгийн үйлчилгээг зохион байгуулах;

7.2.4. хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилт, газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл олголт, барилга байгууламжийн чанар, паспортжуулалт, бүртгэлийн ажлыг зохион байгуулах;

7.2.5. энэ хуульд заасан тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн үйл ажиллагаа, барилгын норм, дүрэм, стандарт, материалын чанар, зураг төслийн хэрэгжилтэд хяналт тавих;

7.2.6. барилгын зураг төсөл, барилгын ажил, барилгын материалын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас барилгын тухай хууль тогтоомж хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих;

7.2.7. барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавих.

8 дугаар зүйл. Төрийн бус байгууллагын оролцоо

8.1. Барилгын салбарын төрийн бус байгууллагууд нь барилгын тухай хууль тогтоомж, норм, дүрэм, стандарт, эрх зүйн бусад баримт бичгийг боловсронгуй болгох, төрөөс үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулна.

8.2. Төрийн бус байгууллага энэ хуулийн 8.1-д заасан ажлыг гэрээгээр гүйцэтгэж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Барилга байгууламж, барилгын зураг төсөл, материал, бүтээгдэхүүн, гэрээнд тавих шаардлага, барилгын зураг төсөлд магадлал хийх

9 дүгээр зүйл. Барилга байгууламжид тавих шаардлага

9.1. Барилга байгууламж дараахь шаардлагыг хангасан байна:

9.1.1. хүн ажиллаж, амьдрах таатай нөхцөл бүрдүүлсэн, түүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, аюулгүй байдлыг хангасан;

9.1.2. энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан шаардлага хангасан зураг төслийн дагуу баригдсан;

9.1.3. хөгжлийн бэрхшээлтэй иргэний хэрэгцээг хангасан;

9.1.4. зэргэлдээ барилга байгууламжийн ашиглалтын хэвийн нөхцөл байдлыг алдагдуулаагүй;

9.1.5. үйлдвэрлэлийн гоо зүй, байгаль орчны нөхцөл, шаардлагад нийцсэн.

10 дугаар зүйл. Барилгын зураг төсөлд тавих шаардлага

10.1. Барилгын зураг төсөл дараахь шаардлагыг хангасан байна:

10.1.1. зургийн даалгавар, зураг төсөл зохиох норм, дүрэм, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, газрын зөвшөөрөл, инженер-геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцөлийн дагуу зохиогдсон;

10.1.2. материал, түлш, эрчим хүч, усны нөөцийг хэмнэлттэй ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн;

10.1.3. хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээг хангах арга хэмжээг тусгасан;

10.1.4. гудамж, талбай, амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэг зэрэг нийтийн эзэмшлийн газрыг чөлөөтэй ашиглах нөхцөлийг хангасан;

10.1.5. усан хангамж, ариутгах татуурга, цахилгаан, дулаан, холбооны хэрэгсэл, байгалийн гэрэл ашиглах боломжийг хязгаарлаагүй;

10.1.6. дуу чимээ, доргио, утаа, хорт хий, өндөр үелзлэл, хог хаягдал, цацраг идэвхт бодис, хөрсний бохирдлоос хүрээлэн байгаа орчныг хамгаалсан;

10.1.7. шаардлагатай тохиолдолд иргэний хамгаалалтын арга хэмжээг тусгасан.

11 дүгээр зүйл. Барилгын материал, бүтээгдэхүүнд тавих шаардлага

11.1. Барилгын материал, бүтээгдэхүүн дараахь шаардлагыг хангасан байна:

11.1.1. стандарт, зураг төслийн чанарын шаардлагыг бүрэн хангасан байх;

11.1.2. хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөгүй байх;

11.1.3. гарал үүсэл, чанарыг баталгаажуулсан паспорт, лабораторийн батламжтай байх;

11.1.4. чанарын шаардлагыг хангасан зориулалтын сав, баглаа боодол, хаяг, шошго, тавиур, чингэлэгтэй байх.

12 дугаар зүйл. Барилгын гэрээнд тавих шаардлага

12.1. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх барилгын материал үйлдвэрлэх, зураг төсөл зохиогч, хөрөнгө оруулагчаас чанарын хяналт тавих, худалдан борлуулахтай холбогдсон ажиллагааг гэрээгүйгээр гүйцэтгэхийг хориглоно.

12.2. Барилгын гэрээг Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан нөхцөл, шаардлагад нийцүүлэн байгуулна.

12.3. Тендер шалгаруулалтад шалгарсан иргэн, хуулийн этгээд нь тендерээр авсан эрхээ бусдад шилжүүлэх, худалдахыг хориглоно.

12.4. Барилгын чанарын баталгаат хугацаа гурван жил байна.

12.5. Энэ хуулийн 12.4-т заасан хугацаа дуусгавар болох үед ашиглагч, гүйцэтгэгч, өмчлөгч хамтран үзэлг хийж шаарддаг арга хэмжээ авснаар баталгаат хугацаа дуусгавар болно.

13 дугаар зүйл. Барилгын зураг төсөлд магадлал хийх

13.1. Барилгын зураг төсөлд хийх магадлалыг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 6.2.8-д заасны дагуу сонгосон иргэн, хуулийн этгээд болон зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

13.2. Гадаадын эзэл, тусламж, улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх, эсхүл газар хөдлөлтийн 6-гаас дээш баллын бүсэд баригдах, барилга байгууламжийн зураг төсөл, инженер-геологийн төвөгшилттэй нөхцөлийн судалгааны дүгнэлт, техник, эдийн засгийн үндэслэлд магадлал заавал хийлгэнэ.

13.3. Энэ хуулийн 13.2-дахь хэсэг гадаадын зохиогчийн зураг төсөл болон гадаадын

байгууллагатай хамтран боловсруулсан зураг төсөл, хот байгуулалтын баримт бичигт нэгэн адил хамаарна.

13.4.Зураг төсөл зохиогчийн гаргасан алдааг зураг төслийн байгууллага, зохиогч хариуцах бөгөөд магадлал хийсэн этгээд нь зураг төслийн техникийн шийдлийн талаар гаргасан дүгнэлтийнхээ төлөө хариуцлага хүлээнэ.

13.5.Энэ хуулийн 13.2, 13.3-т заасан зураг төсөлд магадлал хийлгээгүй тохиолдолд барилгын ажил эхлэхийг хориглоно.

14 дүгээр зүйл. Барилгын ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл, түүний ангилал

14.1.Барилга байгууламжийн зураг төсөл, барилгын ажил, материал үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ.

14.2.Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж энэ хуулийн 14.1-д заасан тусгай зөвшөөрөл авах өргөдөл тухайн орны эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийг хавсаргана.

14.3. Тусгай зөвшөөрөл олгох асуудлаар урьдчилсан дүгнэлт гаргахдаа техникийн болон санхүүгийн чадавхи, норм, нормативын баримт бичгийн бүрдэлт, мэргэжлийн зэрэгтэй инженер, мэргэжлийн ажилчдын ажлын туршлага зэрэг шалгуур үзүүлэлт, нөхцөл, шаардлагыг харгалзана.

14.4.Энэ хуулийн 14.3-т заасан дүгнэлтийг үндэслэн тусгай зөвшөөрлийг барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр олгоно.

14.5.Дараахь тохиолдолд барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тусгай зөвшөөрлийг цуцалж, энэ тухай нийтэд мэдээлнэ:

14.5.1.энэ хуулийн 9, 10, 11 дүгээр зүйлд тавьсан шаардлагыг зөрчсөн;

14.5.2.тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааг дараалсан 2 жил явуулаагүй.

14.6.Тусгай зөвшөөрөлтэй холбоотой энэ хуульд зааснаас бусад харилцааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай⁹ хуулиар зохицуулна.

14.7.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 14.3-т заасан нөхцөл, шаардлагаар тогтоосон зэрэглэлтэй байна.

14.8.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйл ажиллагааны мэдээ, тайланг баталсан маягтын дагуу гаргаж барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Үндэсний татварын ерөнхий газар болон Үндэсний статистикийн хороонд улирал тутам хүргүүлнэ.

14.9.Цамхаг, тулгуур, түшиц хана зэрэг 30 метрээс дээш өндөр, 60 метрээс дээш алгасалтай байгууламж, 16-гаас дээш давхар барилгын зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг зөвхөн тухайн барилга байгууламжийн хувьд олгоно.

14.10.Энэ хуульд зааснаар зөвшөөрөл авсан зураг төслийг давтан хэрэглэхэд энэ хуулийн 14.9 дэх хэсэг хамаарахгүй.

14.11.Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн мэдээллийн сантай байх бөгөөд тухайн сангийн мэдээлэл нийтэд нээлттэй байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Барилгын хөрөнгө оруулагч, захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч, материал үйлдвэрлэгчийн эрх, үүрэг

15 дугаар зүйл. Барилгын хөрөнгө оруулагч, захиалагчийн эрх, үүрэг

15.1.Барилгын хөрөнгө оруулагч, захиалагч нь Иргэний хуульд зааснаас гадна дараахь эрх, үүрэгтэй:

15.1.1.барилга байгууламж барих газрын зөвшөөрөл авах, техникийн нөхцөл бүрдүүлэх, зураг төсөл захиалах;

⁹ Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2001 оны 6 дугаарт нийтлэгдсэн.

15.1.2.барилгын ажлын явц, чанарт хяналт тавих, фото зургаар баримтжуулсан ил, далд ажлын акт, барилгын ажлын гүйцэтгэлийг баталгаажуулах.

15.1.3.барилга байгууламж барих талбайг чөлөөлөх, ашиглалтад оруулах зардлыг хариуцах;

15.1.4.барилга байгууламж барих, шинэчлэх, засварлахтай холбогдон гудамж, зам, талбай сэтлэх, шугам сүлжээ барих, түүнд холболт хийх, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулбал нөхөн сэргээх ажил, үүнд шаардагдах зардлыг хариуцах;

15.1.5.барилга байгууламжийн орчны тохижилтыг иж бүрэн гүйцэтгэх;

15.1.6.барилгын зураг төсөл, барилгын ажилд хөндлөнгийн хяналт хийлгэх;

15.1.7.барилга байгууламжийн баталгаат хугацаанд илэрсэн зөрчлийг арилгуулах.

15.2.Зураг төсөлгүй барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахыг хориглоно.

15.3.Барилгын хөрөнгө оруулагч нь захиалагчийн болон зөвлөх үйлчилгээг барилгын мэргэжлийн этгээдээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

15.4.Газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл олгоогүй, зураг төсөл нь боловсруулагдаж дуусаагүй орон сууцны барилгад иргэдээс хөрөнгө төвлөрүүлэхийг хориглоно.

15.5.Ашиглалтад хүлээлгэж өгөөгүй барилга байгууламжийг барилгын ажлын явцад шаардагдах цахилгаан, дулаан, халуун, хүйтэн усаар түр хангах бөгөөд байнгын ашиглалтад хүлээн аваагүй барилга байгууламжийг цахилгаан, холбоо, дулаан, халуун, хүйтэн усаар хангахыг хориглоно.

16 дугаар зүйл. Барилгын ажил гүйцэтгэгчийн эрх, үүрэг

16.1.Барилгын ажил гүйцэтгэгч нь Иргэний хуульд зааснаас гадна дараахь эрх, үүрэгтэй:

16.1.1.барьж байгаа барилга байгууламжийг болзошгүй байгалийн гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах арга хэмжээ авах, барилга байгууламж барих, өргөтгөл, шинэчлэл, засвар хийх явцад байгаль орчин, эрүүл ахуй, галын хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг биелүүлэх;

16.1.2.энэ хуулийн 23.1.1-д заасан зардлыг барилгын төсөвт өртөгт тусган энэ хуулийн 6.2.5-д заасан санд шилжүүлэх;

16.1.3.барилга байгууламжийн чанарын баталгаат хугацаа дуусаагүй байхад өөрийнх нь буруутай үйл ажиллагааны улмаас үүссэн чанарын зөрчлийг өөрийн зардлаар арилгах;

16.1.4.барилга байгууламж барих, шинэчлэх, өргөтгөх, засварлахтай холбогдон гудамж, зам, талбай сэтлэх, шугам сүлжээ барих, түүнд холболт хийх, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн буцаан сэргээх;

16.1.5.барилгын талбай дахь хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааг хангах.

16.2. Барилгын ажлыг зураг төсөлгүйгээр гүйцэтгэхийг хориглоно.

16.3.Барилга байгууламж барих, шинэчлэх, өргөтгөх, засварлах ажилд олон улсын болон үндэсний стандартын шаардлага хангаагүй, гарал үүсэл, тохирлын гэрчилгээгүй материал, эдлэхүүн хэрэглэхийг хориглоно.

16.4.Байгаль, цаг уурын нөхцөлд тохирох нь баталгаагүй импортын материал, эдлэхүүн хэрэглэхийг хориглоно.

16.5.Импортын барилгын материал гарал үүсэл, тохирлын гэрчилгээтэй байна.

16.6.Барилга угсралтын ажлыг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр эхлэх, үргэлжлүүлэхийг хориглоно.

16.7.Барилгын ажлын явцад анхны зураг төслөөс өөрчлөгдөж гүйцэтгэсэн үе шатны ажил

бүрт гүйцэтгэлийн зураг боловсруулж баталгаажуулна.

16.8 Сонгон шалгаруулалтад оролцож барилгын ажлын гүйцэтгэгчийн эрх авсан тусгай зөвшөөрөл эзэмшигч нь барилга, байгууламжийн үндсэн ажлыг бие даан гүйцэтгэнэ.

16.9 Барилга байгууламжийн үндсэн ажилд суурь, хана, хучилт, шат, араг бүтээц, дээврийн ажил орно.

17 дугаар зүйл. Зураг төсөл зохиогчийн эрх, үүрэг

17.1. Зураг төсөл зохиогч нь Иргэний хууль, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуульд¹ зааснаас гадна дараахь эрх, үүрэгтэй:

17.1.1. тусгай зөвшөөрлийн үндсэн дээр зураг төсөл боловсруулах ажил, үйлчилгээ эрхлэх;

17.1.2. энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан шаардлагын дагуу зураг төсөл боловсруулж, баталгаажуулах;

17.1.3. энэ хуулийн 15.1.2-т заасны дагуу барилгын ажлын явцад зохиогчийн хяналт тавих;

17.1.4. барилгын хөрөнгө оруулагч, захиалагч, гүйцэтгэгчийн хүсэлтээр норм, дүрмийн шаардлагын хүрээнд зураг төсөлд өөрчлөлт оруулах;

17.1.5. зураг төслийг зөрчсөн тохиолдолд түүнийг залуулахыг шаардах буюу ажлыг бүрэн зогсоох, эсхүл чанаргүй баригдсан хэсгийг буулгах талаар барилгын мэргэжлийн хяналтын байгууллагад мэдэгдэх;

17.1.6. энэ хуулийн 13.2, 13.3-т заасан зураг төсөлд магадлал хийлгэх;

17.1.7. барилга байгууламжийн гадна тал, орчны тохижилт, архитектур төлөвлөлтийн иж бүрэн шийдлийг гаргаж зохицуулах, хяналт тавих.

18 дугаар зүйл. Барилгын материал үйлдвэрлэгчийн эрх, үүрэг

18.1 Барилгын материал үйлдвэрлэх тусгай

зөвшөөрөл бүхий этгээд нь бусад хууль тогтоомжид зааснаас гадна дараахь эрх, үүрэгтэй:

18.1.1. барилгын норм, дүрэм, стандарт, зураг төслийн шаардлага бүрэн хангасан бүтээгдэхүүн, эдлэхүүнийг үйлдвэрлэх;

18.1.2. Ашигт малтмалын тухай хуульд заасан журмын дагуу барилгын материалын үйлдвэрлэлд хэрэглэх түгээмэл тархацтай ашигт малтмалыг олборлох, боловсруулах, орд газрыг ашиглах;

18.1.3. хууль тогтоомжид заасны дагуу орд газрын ашиглалтын явцад нөхөн сэргээлт хийх;

18.1.4. үйлдвэрлэсэн барилгын материал, бүтээгдэхүүнийхээ чанарт баталгаа өгөх;

18.1.5. барилгын материал, түүхий эд, бүтээгдэхүүнийг итгэмжлэгдсэн лабораторийн сорилт туршилтад тогтмол хамруулан технологийн заавар боловсруулж, тохирлын гэрчилгээ авсан байх;

18.1.6. үйлдвэрлэсэн барилгын материал, бүтээгдэхүүнийхээ чанарын үндсэн үзүүлэлтийг тодорхойлох лабораторитай байх;

18.1.7. итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлтийг үндэслэн барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосны дагуу шинэ материал, хийц эдлэхүүнийг үйлдвэрлэж, туршилтын журмаар хэрэглэх.

ТАВДУГААР БҮЛЭГ

Барилга байгууламжийн ашиглалт, норм, нормативын баримт бичиг, бүртгэл мэдээлэл

19 дүгээр зүйл. Барилга байгууламжийн ашиглалтад оруулах

19.1. Технологийн хувьд нэгдмэл бус барилгыг хэсэгчлэн ашиглалтад оруулж болно.

19.2. Барьж дуусаагүй, дууссан боловч ашиглалтад хүлээж аваагүй барилга байгууламжийг ашиглахыг хориглоно.

¹ Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2006 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

20 дугаар зүйл. Барилга байгууламжийг ашиглах

20.1. Өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нь барилга байгууламжийг ус, агаар, хөрсний бохирдлоос сэргийлэх, хот байгуулалт, ашиглалтын дүрмийн шаардлагын дагуу ашиглана.

20.2. Өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нь барилга байгууламжид эвдрэл, гэмтэл учруулах, зохих мэргэжлийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр бүтээц, төлөвлөлт, зориулалтыг өөрчлөх, тухайн барилга байгууламж дотор байгаль орчин, хүний амь нас, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж ашиглалтын хэвийн нөхцөлийг алдагдуулж болзошгүй үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

20.3. Өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нь ашиглалтын дүрэмд заасан хугацаанд барилга байгууламжид үзлэг, шалгалт явуулж, илэрсэн зөрчлийг арилгах, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн хяналтын байгууллагад мэдэгдэх зэрэг арга хэмжээ авч, ашиглалтын хэвийн нөхцөл, аюулгүй байдлыг хангуулж ажиллана.

20.4. Ашиглалтын явцад барилга байгууламжид эвдрэл, гэмтэл учрах, нурах тохиолдолд гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч, өмчлөгч, эзэмшигч, ашиглагч, материал үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч, зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийн хэн бүрүүтэй нь хариуцлага хүлээнэ.

21 дүгээр зүйл. Барилгын баримт бичгийг бүрдүүлэх, хадгалах

21.1. Өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нь барилга байгууламжийн ашиглалт, өргөтгөл, шинэчлэл, их засварын тухай төрийн захиргааны төв байгууллагын баталсан журмын дагуу хувийн хэрэг хөтөлнө.

21.2. Хөрөнгө оруулагч, захиалагч нь ашиглалтад оруулсан барилга байгууламжийн газрын зөвшөөрөл, тэг тэнцлэг таталтын акт, зураг төсөл, ил, далд ажлын гүйцэтгэлийн акт, гадна шугам сүлжээний гүйцэтгэлийн зураг, барилгын ажлын чанар, явцад зохиогч болон мэргэжлийн хяналт гүйцэтгэгчийн дүгнэлт, ашиглалтад хүлээлгэн өгсөн баримт бичгийг тухайн барилга байгууламжийг ашиглалтад хүлээлгэн өгснөөс хойш 1 сарын дотор холбогдох архивт шилжүүлнэ.

21.3. Барилга байгууламжийн зураг төсөл, бичиг баримтыг тухайн барилга байгууламжийг ашиглах хугацаагаар хадгална.

22 дугаар зүйл. Барилгын норм, нормативын баримт бичиг

22.1. Барилгын норм, нормативын баримт бичгийг заавал мөрдөнө.

22.2. Норм, нормативын баримт бичгийг барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж мөрдүүлнэ.

22.3. Норм, нормативын баримт бичгийг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр хувилж олшруулахыг хориглоно.

23 дугаар зүйл. Барилгын норм, норматив боловсруулах сан

23.1. Барилгын норм, норматив боловсруулах сан дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

23.1.1. барилга байгууламжийн төсөвт өргтийн 0.18 хувиар авсан орлого;

23.1.2. норм, нормативын борлуулалтын орлого;

23.1.3. норм, нормативыг боловсруулж болгох зориулалтаар өгсөн хандивын орлого.

23.2. Барилгын норм, нормативыг боловсруулах сангийн хөрөнгийг норм, нормативын баримт бичгийг боловсруулах, шинэчлэх зорилгоор зарцуулна.

24 дүгээр зүйл. Барилгын салбарын бүртгэл, мэдээлэл

24.1. Улсын хэмжээнд барилгын талаар нэгтгэж гаргах салбарын бүртгэл, мэдээллийн маягтыг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Үндэсний статистикийн хороо хамтран батална.

24.2. Экспорт, импортын барилгын материал, тоног төхөөрөмж, машин техникийн бүртгэлийг "Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем"-ийн дагуу улирал бүр гаргана.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Барилга байгууламжид тавих техникийн хяналт

25 дугаар зүйл. Барилгын техникийн улсын хяналтыг хэрэгжүүлэх байгууллага

25.1. Барилга байгууламжид тавих техникийн хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллагад ажиллах барилгын улсын байцаагч, зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд длаашид "хяналт хэрэгжүүлэгч" гэх/ тус тус хэрэгжүүлнэ.

25.2. Барилгын техникийн хяналт хэрэгжүүлэгч нь Төрийн хяналт шалгалтын тухай хууль⁸-д заасан эрх, үүргээс гадна дараахь чиглэлээр хяналт шалгалт явуулна:

25.2.1 шинээр барьж байгаа барилга байгууламж, тэдгээрийн шинэчлэл, их засварын ажлын чанар;

25.2.2. барилгын материал, түүхий эд, эдлэхүүний чанар;

25.2.3. хот байгуулалтын баримт бичиг, зураг төслийн хэрэгжилт;

25.2.4. барилга байгууламжийн ашиглалт;

25.2.5. өргөх байгууламж /0,1 тонноос дээш даацтай цахилгаан шат, 3 тонноос дээш даацтай, машинчийн бүхээг бүхий кран/-ийн угсралт, ашиглалтын үеийн аюулгүй ажиллагаа;

25.2.6. барилга, байгууламжийн зураг төсөл, инженер-геологийн судалгааны ажлын чанар;

25.2.7. барилга байгууламжийн нуралт, эвдрэл, өргөх байгууламжид гарсан ослын шалтгаан;

25.2.8. барилга байгууламж, өргөх байгууламжийн улсын бүртгэл;

25.2.9. барилгын ажлын гүйцэтгэлийн магадлан шалгалт;

25.2.10. зураг төсөл боловсруулах, магадлан хийх, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материал үйлдвэрлэхтэй холбогдсон зөрчлийг шалгаж дүгнэлт гаргах;

25.2.11. энэ хуулийн 15.1.7 дахь заалтын хэрэгжилтэд хяналт тавих.

25.3. Барилгын техникийн хяналт хэрэгжүүлэгчийн шийдвэр үндэслэлгүй байвал түүнийг дээд шатны улсын байцаагч хүчингүй болгоно.

25.4 Дээд шатны улсын байцаагч нь хяналт хэрэгжүүлэгчийн шийдвэрийн талаар гарсан маргааныг хянан шийдвэрлэхдээ техник, технологийн асуудлаар түүний гаргасан дүгнэлтийг мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлнэ.

25.5. Улсын ерөнхий байцаагчийн шийдвэрийн талаар гарсан маргааныг шүүх шийдвэрлэнэ.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

26 дугаар зүйл. Барилгын тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

26.1. Барилгын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч, барилгын техникийн хяналтын улсын байцаагч дор дурдсан хариуцлага хүлээлгэнэ:

26.1.1. тусгай зөвшөөрөлгүйгээр барилга байгууламжийн зураг төсөл бол: өвсруулах, барилга угсралтын ажил, материал үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээ эрхэлсэн иргэнийг 500000-1000000 хүртэл, хуулийн этгээдийг 2000000-4000000 хүртэл төгрөгөөр торгож, зөвшөөрөлгүйгээр барьсан барилгыг буулгах, газрыг нөхөн сэргээхэд гарах зардлыг буруутай этгээдээр төлүүлэх;

26.1.2. энэ хуулийн 10, 11, 12, 16, 17, 18, 22 дугаар зүйл, 9.1.1, 9.1.3, 9.1.4, 9.1.5, 13.2, 13.5, 14.1, 14.8, 15.1-д заасан журмыг зөрчсөн иргэнийг 250000-500000, хуулийн этгээдийг 1000000-2000000 хүртэл төгрөгөөр торгох;

26.1.3. энэ хуулийн 9.1.2 дахь заалт, 15.4, 15.5, 19.2, 20.1, 20.2, 20.4 дэх хэсэг, 21 дүгээр зүйлд заасныг зөрчсөн иргэнийг 500000-1000000, хуулийн этгээдийг 2000000-4000000 төгрөгөөр торгож, учруулсан хохирлыг арилгахтай холбогдон гарах зардлыг төлүүлэх.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН**

⁸ Төрийн хяналт шалгалтын тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2003 оны 2 дугаарт нийтлэгдсэн.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 02 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1998 оны 8 дугаар сарын 7- төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж ны өдөр батлагдсан Барилгын тухай хуулийг мөрдөнө. хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Барилгын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 02 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.8.10 дахь заалтын "барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил эрхлэх" гэсний дараа ", барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Барилгын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн албаны тухай хуулийн 5, 7, 8, 10, 15, 16, 17, 22, 27, 28, 30, 33, 35, 38, 39 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй.

"8.1.7.Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бүчгийн дарга."

1/5 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

"5.5.Энэ хуулийн 5.4-т заасан төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаатай адилтгах албан тушаалтны зэрэглэлд хамаарах төрийн жинхэнэ албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг Төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтооно."

4/ 10 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:

"10.6.Улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч нь төрийн албан тушаал эрхлэх хугацаандаа улс төрийн аливаа нам, хөдөлгөөний үйл ажиллагаанд ямар нэг хэлбэрээр оролцохгүй байх, хэрэв улс төрийн намын гишүүн бол намын гишүүнээс түдгэлзэж, тухайн төрийн албан тушаалд томилогдсон өдрөөс хойш 7 хоногийн дотор энэ тухайгаа байгууллагын захиргаа болон харьяалах намдаа бичгээр албан ёсоор мэдэгдэнэ."

2/7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 12 дахь заалт:

"7.1.12.баг, хорооны Засаг дарга,"

5/ 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 14 дэх заалт:

3/8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт:

"15.1.14.Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурал, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн сурталчилгаанд

аливаа хэлбэрээр оролцох, түүнд зориулалтын бус төсвийн хөрөнгө зарцуулах, төрийн өмч хөрөнгийг дайчлах, албаны унаа ашиглах.”

6/16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалт:

“16.2.4 хуулийн дагуу цэргийн жинхэнэ алба хаах үүрэг хүлээсэн иргэн төрийн албаны онцлог төрөл болох энэ үүргээ биелүүлээгүй бол;

Тайлбар: 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдөр батлагдсан Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс өмнө 18 нас хүрсэн, түүнчлэн эмнэлгийн магадлагаагаар эрүүл мэндээр тэнцээгүй, хуульд заасан бусад үндэслэлээр цэргийн жинхэнэ албанаас түр буюу бүрмөсөн чөлөөлөгдсөн иргэнд энэ заалт хамаарахгүй.”

7/17 дугаар зүйлийн 14, 15 дахь хэсэг:

“17.14.Төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллага нь төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд орох иргэний бэлтгэл нөөцийн санг төрийн албаны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу бүрдүүлнэ.

17.15.Төрийн албаны төв байгууллага нь төрийн албаны бэлтгэл нөөцийн нэгдсэн санг эрхэлж, төрийн жинхэнэ албаны сул орон тоог төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагын захиалгын үндсэн дээр нөхөх үйл ажиллагааг зохицуулан зохион байгуулна.”

8/22 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“22.4.Төрийн жинхэнэ албан хаагчийг сэлгэн ажиллуулах журмыг Төрийн албаны төв байгууллага тогтооно.”

9/27 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалт:

“27.2.3. төрийн байгууллага өөрчлөн байгуулагдсан (нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх), эсхүл зохион байгуулалтын бүтэц нь өөрчлөгдсөн боловч төрийн албан хаагчийн албан тушаал (ажлын байр) -ын тодорхойлолтод заасан чиг үүрэг хэвээр хадгалагдан үлдсэн бол түүнийг уг албан тушаалд нь үргэлжлүүлэн ажиллуулах, хэрэв тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх албан тушаал (ажлын байр)-ын орон тоо цөөрсөн бол уг албан тушаалыг эрхэлж байсан албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ, мэдлэг, ур чадвар, ажлын дадлага, туршлага зэргийг нь харгалзан тухайн албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хамгийн илүү хангаж байгаа албан

хаагчийг томилох эрх бүхий албан тушаалтан нь шалгаруулж авна.”

10/27 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“27.4.Энэ хуулийн 27.1.5, 27.1.8, 27.2.5-д заасан нэмэлт баталгаатай холбогдох журмыг Засгийн газар тогтооно.”

11/28 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 4, 5 дахь заалт:

“28.4.4. төрийн албаны төв байгууллага нь Үндэсний статистикийн хороо, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох эрх бүхий төрийн бусад байгууллагын оролцоотойгоор хувийн хэвшилд ажиллагчдын адилтгах албан тушаалын дундаж цалингийн судалгааг Улсын Их Хурлаас баталсан журмын дагуу жил бүр гаргах;

28.4.5. төрийн албан хаагчийн албан тушаалын дундаж цалингийн хэмжээ нь хувийн хэвшилд ажиллагчдын адилтгах албан тушаалын цалингийн дунджаас 5.0 буюу түүнээс дээш хувиар бага болсон тохиолдолд албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээ, жишгийг нэмэгдүүлэх тухай саналыг Төрийн албаны төв байгууллага хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулж, төсвийн хүрээний мэдэгдэл хэлэлцэхийн өмнө Улсын Их Хуралд танилцуулж зохих журмын дагуу шийдвэрлүүлэх.”

12/30 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэр:

“Нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журмыг Төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.”

13/33 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсэг:

“33.4.Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 45.1-д заасан төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг Төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтооно.

33.5.Энэ хуулийн 33.4-т зааснаас бусад төрийн жинхэнэ албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг төрийн жинхэнэ албан тушаалын ангилал, зэрэглэл бүрээр төрийн албаны төв байгууллага тогтооно.”

14/35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 14, 15 дахь заалт:

“35.1.14.төрийн албаны шинэтгэл болон сайн засаглалын зарчмыг хэрэгжүүлэх,

өөрчлөлтийн менежмент, төрийн захиргааны болон хүний нөөцийн менежментийн асуудлаар гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, тэдгээрийн удирдах ажилтныг мэргэшил, арга зүйн зөвлөгөө, үйлчилгээгээр хангах;

35.1.15 төрийн албаны чадавхийг бэхжүүлэх чиглэлээр гадаад орон, олон улсын байгууллагаас төрийн албанд олгож буй эзэл, тусламжийн хүрээнд хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаархи мэдээллийг судлан боловсруулж, тэдгээрийн давхардал, хийгдэж буй арилгах, үр нөлөөг дээшлүүлэх талаар зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх;

15/38 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

"38.4 Засгийн газрын агентлаг, төсвийн бусад байгууллага нь үйл ажиллагааныхаа орлогоос санхүүждэг болж өөрчлөгдсөн бол энэ хуулийн 7.1.7-д зааснаас бусад төрийн албан хаагчид нь төрийн албанаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөж, тухайн байгууллагадаа үргэлжлүүлэн ажиллаж болох бөгөөд энэ тохиолдолд тэдний эрх зүйн байдлыг холбогдох хуулиар зохицуулна."

16/39 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт:

"39.1.2 Энэ хуулийн 35.1.6-д заасны дагуу томилогдсон буюу чөлөөлөгдсөн төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтан, уг албан тушаалд нэр дэвшигчийн өөрийнх нь гомдлоор үүссэн маргаан,"

17/39 дүгээр зүйлийн 5, 6, 7 дахь хэсэг:

"39.5 Төрийн жинхэнэ албаны хүний нөөцийн удирдлагатай холбогдон гарсан эрх бүхий албан тушаалтны шийдвэр хууль зүйн үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол төрийн албаны төв байгууллага өөрчлөх буюу хүчингүй болгох эрхтэй.

39.6 Төрийн албаны төв байгууллагын гаргасан шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтан биелүүлэх үүрэгтэй.

39.7 Төрийн албаны төв байгууллагын шийдвэрийг эс зөвшөөрсөн тал уг шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргаж болно."

2 дугаар зүйл. Төрийн албаны тухай хуулийн дараахь зүйл, хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 12 дахь заалт:

"6.1.12. аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, тэдгээрийн орлогч;"

2/7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"7.1. Төрийн захиргааны албан тушаалд төрийн бодлого боловсруулахад мэргэшлийн зөвлөгөө өгөх, уг бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах чиг үүрэг бүхий дараахь албан тушаал хамаарна:"

3/7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт:

"7.1.3. Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны болон энэ хуулийн 8.1.2-т зааснаас бусад Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн хорооны ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал;"

4/7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт:

"7.1.7. Монгол Улсын яамны Төрийн нарийн бичгийн дарга, яам болон хуульд өөрөөр заагаагүй бол тохируулах, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий улсын төсвөөс санхүүждэг Засгийн газрын агентлагийн удирдах ба гүйцэтгэх албан тушаал, үйл ажиллагааныхаа орлогоос санхүүждэг Засгийн газрын агентлагийн дарга, төсвийн бусад байгууллагын ерөнхий менежерийн үүрэг гүйцэтгэх дарга (захирал, эрхлэгч);"

5/7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт:

"7.1.10. Засгийн газраас байгуулсан төрийн захиргааны бусад төсөвт байгууллагын болон хуульд өөрөөр заагаагүй бол аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх улсын төсвөөс санхүүждэг нутгийн захиргааны байгууллагын удирдах ба гүйцэтгэх албан тушаал;"

6/7 дугаар зүйлийн 5-10 дахь хэсэг:

"7.5. Эрхэлсэн түшмэлийн албан тушаалд яамны газрын дарга, түүний орлогч, хэлтсийн дарга, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал хамаарна.

7.6. Ахлах түшмэлийн албан тушаалд яамны тэсгийн дарга, ахлах шинжээч, шинжээч, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал хамаарна.

7.7. Дэс түшмэлийн албан тушаалд яамны ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн, ахлах зохион

байгуулагч, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал хамаарна.

7.8. Туслах түшмэлийн албан тушаалд яамны зохион байгуулагч, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал хамаарна.

7.9. Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх, Үндсэн хуулийн цэц, Улсын ерөнхий прокурорын газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Төрийн албаны зөвлөл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Сонгуулийн ерөнхий хороо, Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн хороо, Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалын ангилал, зэрэглэлийг Төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтооно.

7.10. Яам, төрийн бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

7/8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"8.1. Төрийн тусгай албан тушаалд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд заасан журмын дагуу үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, хууль дээдлэх үндсэн зарчмыг сахиулах, нийгмийн хэв журмыг хамгаалахтай холбогдсон төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх дараахь албан тушаал хамаарна:"

8/8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт:

"8.1.3. Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн дарга, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, гишүүн, Үндэсний болон орон нутгийн аудитын газар, Авлигатай тэмцэх газрын удирдах ба гүйцэтгэх албан тушаал;"

9/9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

"9.1. Төрийн үйлчилгээний албан тушаалд төрийн суурь үйлчилгээг адил тэгш, чанартай, хүртээмжтэй хүргэх болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах чиг үүрэг бүхий хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажиллах дараахь албан тушаал хамаарна:"

10/9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт:

"9.1.2. Боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёл, урлаг зэрэг улсын төсвөөс санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагын дарга (захирал, эрхлэгч)-аас бусад удирдах ба гүйцэтгэх, туслах албан тушаал;"

11/9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт:

"9.1.4. Яам, агентлагийн харьяа буюу дэргэд ажилладаг, улсын төсвөөс санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагын удирдах ба гүйцэтгэх албан тушаал."

12/9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

"9.2. Төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно."

13/10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"10.2. Энэ хуулийн 5.1.1, 5.1.3-т заасан албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг хууль тогтоомжоор тогтооно."

14/10 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсэг:

"10.4. Энэ хуулийн 5.1.2-т заасан албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно."

10.5. Энэ хуулийн 5.1.4.-т заасан албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг болон улс төрийн аливаа нөлөөлд автахгүй төвийг сахихтай холбогдсон зохицуулалтыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн хөдөлмөрийн дотоод журам болон хөдөлмөрийн гэрээ, контрактаар тодорхойлно."

15/17 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг:

"17.2. Энэ хуулийн 10.1-д заасан ерөнхий болон 33.5-д заасан тусгай шаардлага, 16 дугаар зүйлд заасан болзлыг хангасан Монгол Улсын иргэн төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх эрхтэй."

17.3. Төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх хүсэлтэй, энэ хуулийн 10.1-д заасан ерөнхий болон 33.5-д заасан тусгай шаардлагыг хангасан иргэдийг өрсөлдүүлэн шалгаруулах зорилгоор тэднээс төрийн албаны мэргэшлийн шалгалт /цаашид "мэргэшлийн шалгалт" гэх/ авч онооны дэс дарааллаар төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэнэ. Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний сонгон шалгаруулалтад тэнцэж, тухайн албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хамгийн илүү хангаж байгаа нэг иргэнийг төрийн албаны төв байгууллага сонгон түүнийг томилох эрх бүхий этгээдэд нэр дэвшүүлнэ."

16/28 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

"28.5. Улс төрийн болон тусгай албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагч /сум, дүүргийн Засаг дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын орлогч, зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тусгай албан тушаалаас бусад/-ийн албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно."

17/28 дугаар зүйлийн 10 дахь хэсэг:

"28.10. Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлд хамаарах албан тушаалтны цалингийн хэмжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтооно."

18/34 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэг:

"34.3. Зөвлөл нь хамтын удирдлагын зарчмаар ажиллах бөгөөд дарга, 6 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Тэдгээрийн 2 нь орон тооны, 4 нь орон тооны бус байна.

34.4. Зөвлөлийн орон тооны 2 гишүүнд Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар тус бүр нэг хүний нэр дэвшүүлэх бөгөөд нэр дэвшигч нь төрийн жинхэнэ албан тушаалд 15-аас доошгүй жил ажилласан, мэргэшсэн, ял шийтгэлгүй, 40 нас хүрсэн Монгол Улсын иргэн байна."

19/34 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг:

"34.7. Зөвлөлийн даргыг Ерөнхийлөгчийн санал болгосноор Улсын Их Хурал 6 жилийн хугацаагаар томилох бөгөөд нэр дэвшигч нь төрийн жинхэнэ албан тушаалд 15-аас доошгүй жил ажилласан, удирдах ажлын дадлага, туршлагатай, ял шийтгэлгүй, 45 нас хүрсэн Монгол Улсын иргэн байна."

20/34 дүгээр зүйлийн 13 дахь хэсэг:

"34.13. Зөвлөл нь орон тооны болон орон тооны бус салбар зөвлөл, ажлын албатай байна. Ажлын албаны даргыг Төрийн албаны зөвлөл томилж, чөлөөлнө. Орон тооны салбар зөвлөл болон ажлын албаны зохион байгуулалтын бүтэц, орон тоо, төсвийг Улсын Их Хурал батална. Төрийн албаны төв байгууллага нь дэргэдээ сургалт, судалгааны болон зөвлөх үйлчилгээний нэгжтэй байж болно."

21/35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дахь заалт:

"35.1.1. төрийн албаны шинэтгэлийн стратегийн төлөвлөлт, төрийн боловсон хүчний бодлогын удирдамжаар хангах, тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах;

35.1.2. төрийн албаны тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, төрийн албанд шударга ёсны зарчмыг хэрэгжүүлэх мэргэшил, арга зүйн удирдлагаар хангах, төрийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан стандартын хэрэгжилтийг шалган зааварлах, зөрчлийг арилгуулах хугацаатай үүрэг өгөх, гүйцэтгэлд нь хяналт тавих, энэ хуулийн 39.1-д заасан маргааныг хянан шийдвэрлэх, албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас төрд учруулсан хохирлыг арилгуулахаар төрийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргах;"

22/35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5-13 дахь заалт:

"35.1.5. төрийн байгууллагын ажлын албаны төрийн жинхэнэ албан хаагчийн удирдлагатай холбогдсон үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, төрийн байгууллагын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлох болон төрийн үйлчилээний чанар, хүртээмжид нийгмийн аудит хийх арга зүйг нэвтрүүлэх талаар зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх замаар төрийн байгууллагуудын үйл ажиллагааны үр ашгийг үр нөлөөг дээшлүүлэх болон төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг арга зүйн удирдлагаар хангах;

35.1.6. төрийн захиргааны болон хуульд өөрөөр заагаагүй бол төрийн тусгай албаны удирдах албан тушаалд томилогдох нэг ажилтныг Улсын Их Хурлаас тогтоосон журмын дагуу сонгон шалгаруулж, нэр дэвшигчийн талаархи дүгнэлтээ уг ажилтныг томилох эрх бүхий байгууллагад өгөх;

35.1.7. хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтанд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулахтай холбогдсон зөвлөгөө өгөх, арга зүйн удирдлагаар хангах;

35.1.8. төрийн байгууллагын өөрчлөлт, хөгжлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн хүний нөөцийн төлөвлөлтийн арга зүйн удирдлагаар хангах, төрийн жинхэнэ албаны боловсон хүчний хэрэгцээг төлөвлөх, хангалтыг зохион байгуулах;

35.1.9. төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын ажлыг арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангах;

35.1.10. төрийн жинхэнэ албан хаагчийн мэдлэг, үр чадварыг дээшлүүлэх, удирдах ажилтны манлайлах үр чадварыг нэмэгдүүлэх сургалт болон төрийн албатай холбогдсон судалгаа, шинжилгээний ажлыг зохион байгуулах, зохицуулах;

35.1.11. төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг боловсруулан батлахад санал өгөх, төрийн байгууллагын чиг үүргийн шинжилгээ хийхэд мэргэшил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах;

35.1.12. төрийн албаны шинэтгэлийн бодлого, стратеги, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ (мониторинг), үнэлгээ хийх, түүний үр дүнд дээшлүүлэх талаар санал, зөвлөмж боловсруулах, улсын болон орон нутгийн төсвийн удирдлагын зардлын төслийг зохиох, хянаж батлахад зохих журмын дагуу санал гаргах;

35.1.13. төрийн байгууллагаас төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр болон ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг арга зүйн удирдлагаар хангах;

23/36 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг:

"36.1. Төрийн албаны стандарт нь төрийн албыг үр дүнтэй удирдах, төрийн байгууллага, төрийн албан хаагчийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулахад чиглэнэ.

36.2. Төрийн албаны стандарт нь төрийн байгууллага чиг үүргээ, төрийн албан хаагч албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн менежментийн үйл ажиллагаанд тавих шаардлагыг тогтооно.

36.3. Төрийн албаны стандартыг Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуульд заасны дагуу боловсруулан баталж мөрдүүлнэ."

24/39 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг:

"39.4. Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан хаагч энэ хуулийн 39.1-д заасан маргаантай холбогдсон гомдлоо төрийн албаны салбар зөвлөл болон төрийн албаны төв байгууллагад 1 сарын дотор гаргана."

25/40 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

"40.2. Төрийн албан хаагч албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглах, бусдыг дарамтлах, хавчин гадуурхах, эрхшээлдээ байлгахыг хориглоно."

26/41 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 3 дахь заалт:

"41.1.1. төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоонд иргэний авч ажиллуулахдаа энэ хуулийн 16.2, 17.1, 17.4-т заасныг зөрчсөн албан тушаалтныг 25000-40000 төгрөгөөр торгох;

41.1.2. хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 39.6-д заасныг зөрчсөн албан тушаалтныг 35000-50000 төгрөгөөр торгох;

41.1.3. энэ хуулийн 25 дугаар зүйл, 26.1-д зааснаас бусад тохиолдолд төрийн жинхэнэ албан хаагчийг ажлаас халсан албан тушаалтныг 45000-60000 төгрөгөөр торгох."

3 дугаар зүйл. Төрийн албаны тухай хуулийн 5.4-ийн "ээрэглэлийг", 20.4, 30.5-ын "журмыг", 31.3-ын "урамшил олгох журмыг", 20.5-ын "ээрэг дэвийг", 28.7-ийн "хангамжийг", 28.8-ын "хэмжээг", 28.9-ийн "доод хэмжээг" гэсний дараа тус тус "төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн" гэж, 12.1-ийн "Монгол Улсын" гэсний өмнө "Хуульд өөрөөр заагаагүй бол" гэж, 8.1.4-ийн "Онцгой байдлын ерөнхий газрын дарга" гэсний дараа ", Шүүхийн шийдвэргүйцэтгэх газрын дарга," гэж, 14.1.6-ийн "зөвлөгөө өгөх," гэсний дараа "байгууллагын удирдлагын зөвшөөрснөөр багшлах," гэж, 15.1.10-ын "хувь нийлүүлсэн" гэсний дараа "болон хамтарсан" гэж, 15.1.12-ын "хувийн" гэсний өмнө "төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой үйлдвэрийн газрын төлөөлөн удирдах зөвлөлийн болон захиргааны гишүүн байх," гэж, 16.3-ын "шийдвэрийг" гэсний дараа "төрийн албаны төв байгууллага" гэж, "албан тушаалтанд" гэсний дараа "шүүгч" гэж, 17.7-ийн "Энэ хуулийн" гэсний дараа "23.2, 24.1.3-т заасан үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдсөн," гэж, 23.2-ын "Улсын Их Хурлын" гэсний дараа ", түүнчлэн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын" гэж, 23.3.2-ын "сургалтаар" гэсний дараа "(шинэ дадлага, туршлага эзэмших сургалтыг оролцуулан)" гэж, 26.1-ийн "Энэ хуулийн" гэсний дараа "13," гэж, "15" гэсний дараа ", 40" гэж, 28.6-гийн "жишгийг" гэсний дараа "хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн" гэж тус тус нэмсүгэй.

4 дүгээр зүйл. Төрийн албаны тухай хуулийн 7.3, 12 дугаар зүйлийн болон 20 дугаар зүйлийн гарчиг, 12.1, 12.2, 20.1, 20.4, 30.2-ын "захиргааны" гэснийг "жинхэнэ" гэж, 8.1.5-ын "дипломат ажилтан" гэснийг "дипломат албан тушаал" 8.1.6, 28.6.3-ын "гамшгаас хамгаалах" гэснийг "онцгой байдлын" гэж, 15.1.1-ийн "олон нийтийн" гэснийг "төрийн бус" гэж, 15.1.8-ын "нутгийн өөрөө удирдах байгууллага" гэснийг "аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөр сонгогдох," гэж, 17.4-ийн "шалгаруулж авна," гэснийг "шалгаруулж авах тухай хүсэлтээ төрийн албаны төв байгууллагад тавина," гэж, 26.1-ийн "дугаар" гэснийг "дүгээр" гэж, 30.2-ын "6 сарын" гэснийг "36 сарын" гэж, 35.1.4-ийн

"Шүүхийн ерөнхий зөвлөлийг" гэснийг "Шүүхийн ерөнхий зөвлөл, бусад сонирхогч этгээдийг" гэж, "7.1.12" гэсэн дугаарыг "7.1.13" гэж, "8.1.7" гэсэн дугаарыг "8.1.8" гэж, "16.2.4", "16.2.5" гэсэн дугаарыг "16.2.5", "16.2.6" гэж, "27.2.3", "27.2.4" гэсэн дугаарыг "27.2.4", "27.2.5" гэж, "33.4" гэсэн дугаарыг "33.6" гэж, "35.1.14" гэсэн дугаарыг "35.1.16" гэж, "39.1.2" гэсэн дугаарыг "39.1.3" гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Төрийн албаны тухай хуулийн 23.5-ын "23.2," гэснийг, 34.9-ийн "Зөвлөлийн орон тооны гишүүнээр томилогдсон

хүний намын гишүүнийг түдгэлзүүлнэ." гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Төрийн албаны тухай хуулийн 6.1.11, 6.1.13, 7.1.5, 10.3, 17.12, 17.13, 39.2-ыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

7 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу Төрийн албаны тухай хуулийн 10.6 дахь заалтыг 2009 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА, САНХҮҮЖИЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 45.1,5 дахь хэсгийн "цагдаа, тагнуул," гэсний дараа "шүүхийн шийдвэр гүйцэтгэх," гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн дараахь хэсгийг дор дурдсанаар тус тус өөрчлөн найруулсугай:

1/45 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэг:

"45.5.Томилох эрх бүхий этгээд төрийн албаны төв байгууллагаас ерөнхий менежерт санал болгосон нэр дэвшигчийг холбогдох албан тушаалд томилно.

45.6.Томилох эрх бүхий этгээд төрийн албаны төв байгууллагын санал болгосон нэр дэвшигчийг томилохоос хуульд заасан үндэслэлээр 1 удаа татгалзах эрхтэй бөгөөд энэ тохиолдолд төрийн албаны төв байгууллага өөр хүнийг зохих журмын дагуу санал болгоно."

3 дугаар зүйл. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 45.1-ийн "3-5 хүний" гэснийг "нэг хүний" гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 21.2-ын "төрийн албаны төв байгууллагаас энэ хуулийн 45 дугаар зүйлд заасны дагуу сонгон шалгаруулж санал болгосон," гэсэн хэсгийг хассугай.

5 дугаар зүйл. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 45.1,8 дахь заалт, 45.7 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдөр батлагдсан Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг "Яамны төрийн нарийн бичгийн даргыг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 45 дугаар зүйлд заасны дагуу Төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар томилж, чөлөөлнө." гэж өөрчлөн найруулсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдөр батлагдсан Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН**



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ЯАМНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9.1, 11.1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

"9.1.Төрийн нарийн бичгийн даргыг Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу Төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар томилж, чөлөөлнө."

2/11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

"11.1.Яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн даргыг Төрийн албаны төв байгууллага нэр дэвшүүлж, Төрийн нарийн бичгийн дарга томилж, чөлөөлнө."

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдөр батлагдсан Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26.2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"26.2.Баг, хорооны Засаг даргад тухайн нэгжийн нийтийн Хуралд оролцож байгаа иргэд төрийн албаны шалгалт өгч тэнцсэн иргэнийг, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад тухайн Хурал дахь нам, эвслийн бүлэг, эсхүл Хурлын төлөөлөгч тус тус нэр дэвшүүлэх эрхтэй бөгөөд уг Хурлын хуралдаанд оролцсон иргэд, төлөөлөгчдийн олонхийн буюу 50-иас дээш хувийн санал авсан нэр дэвшигчийг томилуулахаар томилох эрх бүхий албан тушаалтанд санал болгоно."

2 дугаар зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 9.6, 9.7 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдөр батлагдсан Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн, 2 дугаар зүйлийг 2009 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 28 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 6 дахь хэсэг нэмсүгэй:

"6.Төрийн жинхэнэ болон үйлчилгээний албан хаагч аливаа хэлбэрээр сонгуулийн сурталчилгаанд оролцох, сонгуулийн сурталчилгаа бие даан явуулахыг хориглоно."

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдөр батлагдсан Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

ОРОН НУТГИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Орон нутгийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 30 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

1/30 дугаар зүйлийн 13 дахь хэсэг:

"30.13.Төрийн жинхэнэ болон үйлчилгээний албан хаагч аливаа хэлбэрээр сонгуулийн сурталчилгаанд оролцох, сонгуулийн сурталчилгаа бие даан явуулахыг хориглоно."

2/30 дугаар зүйлийн 20 дахь хэсэг:

"30.20.Энэ хуулийн 30.13-д заасныг зөрчсөн төрийн жинхэнэ болон үйлчилгээний

албан хаагчийг 100000-150000 төгрөгөөр торгоно."

2 дугаар зүйл. Орон нутгийн Хурлын

сонгуулийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн "30.13-30.18" дахь хэсгийн дугаарыг "30.14- 30.19" гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2008 оны 5

дугаар сарын 06-ны өдөр батлагдсан Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсоц өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

ДИПЛОМАТ АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Дипломат албаны тухай хуулийн 9.1.2 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"9.1.2. Дипломат албан тушаал нь төрийн тусгай албан тушаал байна."

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдөр батлагдсан Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

НАМЫН ГИШҮҮНЭЭС ТҮДГЭЛЗВЭЛ ЗОХИХ АЛБАН ТУШААЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Намын гишүүнээс түдгэлзвэл зохих албан тушаалын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 2-8 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдөр батлагдсан Төрийн албаны

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ХЭСГИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 6 дахь хэсгийг тус тус хүчингүйд болсонд тооцсугай.

тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдөр батлагдсан Төрийн албаны

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 08-ны өдөр

Улаанбаатар хот

"ЭХ НЯЛХСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ"-ИЙН ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Итали Улсын Засгийн газар хооронд 2007 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр байгуулсан "Эх нялхсын эрдэм шинжилгээний төвийн үйл ажиллагааг сайжруулах төсөл"-ийн зээлийн хэлэлцээрийг

Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 08-ны өдөр

Улаанбаатар хот

"ДАРХАНЫ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦЫН ТУРБИНИЙГ ШИНЭЧЛЭХ ТӨСӨЛ"-ИЙН ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн босголт хөгжлийн банк хооронд 2007 оны 12 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан "Дарханы дулааны цахилгаан станцын турбинийг шинэчлэх төсөл"-ийн

зээлийн хэлэлцээрийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 08-ны өдөр

Улаанбаатар хот

ЯЛТАН ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын хооронд 2007 оны 5 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан "Ялтан шилжүүлэх тухай гэрээ"-г Монгол Улсын

Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.5-ыг үндэслэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4.3 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

78.3-т заасны дагуу ялгүй болсон буюу ялгүйд тооцогдсон байх."

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 5 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

"27.4.3.ял шийтгүүлж байгаагүй, эсхүл ял шийтгүүлж байсан боловч Эрүүгийн хуулийн 78.2.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

ОРОН НУТГИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Орон нутгийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар зүйлийн "дутуу буюу" гэснийг хассугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИРГЭНД ГАЗАР ӨМЧЛҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

4	Нийслэлийг аймгийн төвтэй холбосон улсын чанартай авто замын дагуух газарт /сумын төвөөс бусад /	0.07 хүртэл га
---	--------------------------------------------------------------------------------------------------	----------------

2 дугаар зүйл. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-ийн "Гэр бүлийн хэрэгцээнд өмчлүүлэх газрын байршил, хэмжээ /га/" гэснийг "Иргэнд өмчлүүлэх газрын байршил, хэмжээ /га/", 41 дүгээр зүйлийн 41.2-ын "2008" гэснийг "2013" гэж тус тус өөрчилсүгэй.

хамтран өмчлөх хэлбэрээр" гэснийг тус тус хассугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 5 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-ийн "иргэн, түүний гэр бүлийн гишүүн", "дундаа

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИРГЭНД ГАЗАР ӨМЧЛҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд дор дурдсан агуулгатай 4 дүгээр зүйл нэмсүгэй:

"4 дүгээр зүйл. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2-т заасны дагуу 2008 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө өмчлүүлсэн газрыг тухайн гэр бүлийн аль нэг гишүүнд өмчлүүлж, бусад гишүүдэд газрыг хууль тогтоомжид заасны дагуу нэг удаа үнэгүй өмчлүүлнэ."

2 дугаар зүйл. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн "5" гэснийг "10", мөн хуулийн 4, 5 дугаар зүйлийн дугаарыг "5, 6" гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2008 оны 5 дугаар сарын 22-ны өдөр батлагдсан Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫГ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хуулийн 6 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 6.5 дахь хэсэг нэмсүгэй:

"6.5. Энэ хуулийн 6.1.1-д заасан хөрөнгийг мөнгөн болон гурил, улаан буудай, бензин шатахууны нөөц хэлбэрээр байршуулж болох бөгөөд Засгийн газар энэ тухай саналаа холбогдох тооцоо, судалгааны хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлж шийдвэрлүүлнэ."

2 дугаар зүйл. Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн "Сангийн" гэсний дараа "мөнгөн" гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 5 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай 10.1.4 дэх заалт нэмсүгэй:

"10.1.4 дотоодын зах зээл дээр гурил, улаан буудай, бензин шатахууны үнэ огцом өсөх."

2 дугаар зүйл. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1

дэх заалтын "зээлийн баталгаа гаргах" гэсний дараа "зээлийн хүүгийн татаас олгох" гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 5 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 23-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 23.3, 44.3 дахь хэсгийн "нэгдсэн бар кодтой байна" гэснийг, 40 дүгээр зүйл, 41 дүгээр зүйлийн 41.2, 41.4 дэх хэсгийг 2012 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус дагаж мөрдөнө."

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 5 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх тухай

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4.5, 6.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

ерөнхий хорооны гишүүний үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2 Энэ тогтоолыг дараагийн гишүүнийг нөхөн томилогдсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

1.Өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Жамъянхорлоогийн Сүхбаатарыг Сонгуулийн

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 06-ны өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

Сонгуулийн хорооны гишүүний ёс зүйн дүрэм батлах тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 14 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

2.Энэ тогтоолыг батлагдсан өдөр буюу 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

1.Сонгуулийн хорооны гишүүний ёс зүйн дүрмийг хавсралтаар баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

Улсын Их Хурлын 2008 оны 25 дугаар тогтоолын хавсралт

СОНГУУЛИЙН ХОРООНЫ ГИШҮҮНИЙ ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

аливаа зөрчил, хууль бус үйлдлээс сэргийлж, нэр төрийг нь хамгаалахад чиглэгдэнэ.

1.1. Бүх шатны сонгуулийн хорооны гишүүн /цаашид "хорооны гишүүн" гэх/-ээс сонгуулийн хорооны бүрэн эрхийг хэрэгжүүлэх, сонгуулийг зохион байгуулах үйл ажиллагаандаа баримтлах зарчим, ёс зүйн хэм хэмжээг тогтоож мөрдүүлэхэд энэхүү дүрмийн зорилго оршино.

1.3. Сонгуулийн ерөнхий хороо, нутаг дэвсгэр, тойрог, түүний салбар, хэсгийн хорооны гишүүн энэ дүрмийг сахин мөрдөнө.

1.4. Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн нь хуульд заасны дагуу Үндсэн хуульд тангараг өргөх ба өргөсөн тангарагтаа үнэнч байна.

1.2. Энэхүү дүрэм нь сонгуулийг шударга, зөв зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлэхийн зэрэгцээ сонгуулийн хорооны гишүүн сонгуулийн хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх, тэднийг

1.5. Хорооны гишүүн нь сонгуулийн бэлтгэл ажлыг бүрэн дүүрэн хангаж, сонгууль, санал

асуулгыг шударга, хуулийн дагуу явуулахад үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллана.

Хоёр. Ёс зүйн хэм хэмжээ

2.1. Хорооны гишүүн нь ёс зүйн дараахь хэм хэмжээг сахин мөрдөнө:

2.1.1. албан үүргээ гүйцэтгэхдээ сонгогчийн эрх ашгийг хүндэтгэн Монгол Улсын сонгуулийн хууль тогтоомж, түүнд нийцүүлэн сонгуулийн хорооноос гаргасан шийдвэрийг чанд дагаж мөрдөх;

2.1.2. хорооны хуралдаан, хэлэлцэх асуудал, гаргасан шийдвэр, түүнийг мэдээлэх, тайлбар өгөх болон бусад ажиллох ил тод явуулах бөгөөд мэдээллийг нуун дарагдуулах, цаг алдагдуулахыг цээрлэх;

2.1.3. сонгуулийн хороо, түүний гишүүдээс нийтэд өгөх мэдээлэл нь хоёрдмол утгагүй, товч тодорхой, эмх цэгцтэй, бодит баримтад тулгуурласан, хуулийн үндэслэлтэй байх;

2.1.4. сонгуулийн ажлыг гүйцэтгэхдээ сонгогчийн эрхийг хүндэтгэн, сонгогчдыг сонгуульд оролцохыг уриалж ажиллах бөгөөд сонгогчидтой соёлтой харилцах, сонгуулийн үйл ажиллагаа, хууль тогтоомжийг үнэн зөв ойлгуулах;

2.1.5. сонгогчдыг сонгуульд чөлөөтэй оролцуулах, ялангуяа өндөр настай, хөгжлийн бэрхшээлтэй, бичиг үсэг мэдэхгүй, алс хол амьдардаг сонгогчдыг сонгуульд оролцох нөхцөлөөр хангахад дэмжлэг үзүүлэх;

2.1.6. хорооны хуралдаанд хууль тогтоомжийг хүндэтгэн, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх;

2.1.7. хорооны гишүүдийн олонхийн саналаар гаргасан шийдвэрийг намын харъяалал, үзэл бодлын зөрүүгээс үл хамааран хүндэтгэн мөрдөж ажиллах;

2.1.8. хэвлэл мэдээллийн хэрэгслээр хорооны гишүүдийн олонхийн саналаар гаргасан хамтын шийдвэрийг ташаа буюу гүйвүүлсэн тайлбар хийхийг цээрлэх;

2.1.9. үйл ажиллагаандаа сонгуулийн байгууллага, ажилтны нэр төрийг хамгаалж ажиллах зарчмыг баримтлах;

2.1.10. нам, эвслийн ажилтан, нэр дэвшигч, сонгогч хэнийг ч үл ялгаварлах, сонгуулийн хороо, бусад гишүүний эрхийг хүндэтгэх, хүлээлгэсэн итгэлийг даах зарчмаар ажиллах;

2.1.11. сонгуулийг зохион байгуулах бүх үйл ажиллагаанд нам, эвсэл, нэр дэвшигчийн

эрх ашгийн үүднээс бус зөвхөн хууль дээдлэх зарчмыг чанд мөрдөж ажиллах;

2.1.12. нам, эвсэл, нэр дэвшигчийн үйл ажиллагааг дэмжих, эсхүл шүүмжлэх, эсэргүүцэх байр сууринаас бус улс төрийн хувьд төвийг сахиж ажиллах;

2.1.13. үйл ажиллагаандаа зан харилцааны доголдол гаргахгүй байхыг эрхэмлэх.

2.2. Хорооны гишүүнд дараахь зүйлийг хориглоно:

2.2.1. хорооны шийдвэр гаргахад бусад гишүүдэд нөлөөлөх, хуралдаан таслах, хуралдаан хаяж явахыг хориглоно;

2.2.2. нам, эвсэл, нэр дэвшигчийн ухуулга сурталчилгаа, хүлээн авалтад оролцох, тэднээс урамшуулал, бэлэг сэлт авах, нам, эвсэл, нэр дэвшигчийн сурталчилгаанд зориулсан зүйл хэрэглэх, аль нэг нэр дэвшигчийн эрх ашигт нийцүүлэн үйл ажиллагаа явуулахыг хориглоно;

2.2.3. сонгуулийн ажил гүйцэтгэж явахдаа болон сонгуулийн ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглоно;

2.2.4. хорооны гишүүний хувьд бусдын өмнө үүрэг хүлээх, албан ажлыг давуу тал, боломжийг хувийн зорилгоор ашиглах, бүүдүүлж зан авир гаргахыг хориглоно;

2.2.5. өөрийн гэр бүл, төрөл садан сонгуульд нэр дэвшсэн тохиолдолд түүнийг дэмжсэн үйл ажиллагаа явуулах, сонгуулийн хороогоор асуудал нь хэлэлцэгдэх, шийдвэр гаргахад оролцох буюу гишүүдэд нөлөөлөхийг хориглоно;

2.2.6. сонгуулийн баримт бичгийг хуурамчаар үйлдэх, сонгуулийн дүнг зориудаар буруу ташаа гаргах, сонгогч саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх эрхийг зөрчих, сонгуулийн дүнд хууль бусаар нөлөөлөхийг хориглоно.

2.3. Хорооны гишүүд нь нэр дэвшигчид, нэр дэвшүүлсэн улс төрийн намын удирдах ажилтан, төрийн бусад албан тушаалтантай уулзсан тухайгаа үнэн зөв мэдээлнэ.

Гурав. Ёс зүйн зөрчил, авах арга хэмжээ

3.1. Сонгуулийн хорооны гишүүний ёс зүйн зөрчил гэж энэ дүрмээр тогтоосон ёс зүйн хэм хэмжээг санаатай буюу санамсаргүй зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг хэлнэ.

3.2. Энэхүү дүрмээр тогтоосон ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн хорооны гишүүнийг хорооны

хуралдаанаар хэлэлцэж, сануулах арга хэмжээ авч дээд шатны сонгуулийн байгууллагад мэдэгдэнэ.

3.3.Энэ дүрмийн 2.2.3 дахь заалтыг зөрчсөн хорооны гишүүнийг тухайн хорооны бүрэлдэхүүнээс огцруулна.

3.4.Ес зүйн зөрчил гаргасан гишүүн өөрөө хорооны гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтээ гаргаж болно.

3.5.Хорооны гишүүн ес зүйн хэм хэмжээг дахин зөрчвөл сонгуулийн хорооны хуралдаанаас түүнийг хорооны гишүүнээс огцруулах тухай саналыг дээд шатны сонгуулийн байгууллага, холбогдох эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

3.6.Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн ес зүйн зөрчил гаргасан, тангарагаасаа няцсан бол тус Хорооны хуралдаанаар авч хэлэлцэнэ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 06-ны өдөр

Дугаар 26

Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 5.4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын 2002 оны 73 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилгах төрийн албан тушаалтны зэрэглэл"-ийн улс төрийн албан тушаалын ТӨ-VA-аас "Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга," гэснийг хасч тусгай албан тушаалын ТӨ-VA-д "Монгол

банкны Ерөнхийлөгч" гэсний өмнө "Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга," гэж нэмсүгэй.

2.Энэ тогтоолыг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдөр батлагдсан Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 06-ны өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16.8 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах

тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх боломжгүй тул хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 09-ний өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгууль товлон зарлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 8.1, 8.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийг 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрөөс товлон зарласугай.

2.Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн санал хураалтыг 2008 оны 6 дугаар сарын 29-ний ням гаригт явуулахаар тогтоосугай.

3.Энэ тогтоолыг 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 31

Улаанбаатар хот

Сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 10.2 дахь хэсэг, Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2008 оны ээлжит сонгуулийн улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээг 7.2 тэрбум төгрөгөөр тогтоосугай.

2. Энэхүү зардлыг улсын төсвөөс гаргахыг Засгийн газар /С.Баяр/-т даалгасугай.

3. Энэ тогтоолыг 2008 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 36

Улаанбаатар хот

Н.Лувсанжавыг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 40.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Намсрайжавын Лувсанжавыг өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Улсын Их Хурлын

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Энэ тогтоолыг 2008 оны 5 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 37

Улаанбаатар хот

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 40.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Данзангийн Сандаг-Очирыг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн

даргаар томилсугай.

2. Энэ тогтоолыг 2008 оны 5 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 22-ны өдөр

Дугаар 40

Улаанбаатар хот

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24.6 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /С.Баяр/-т даалгасугай:

1/Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4-т заасан Монгол Улсын иргэнд нэг удаа үнэгүй өмчлүүлж болох газрын хэмжээ, байршлыг Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг болон холбогдох бусад хуульд нийцүүлэн тогтоох;

2/Энэ тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг зохих журмын дагуу шийдвэрлүүлэх.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 22-ны өдөр

Дугаар 42

Улаанбаатар хот

Засгийн газарт эрх олгох тухай

Гаалийн тарифын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.2008 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд импортлох хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн: улаанбуудайн гурил, хөх тарианы гурил, улаанбуудай-хөх тарианы гурил, гоймон; цагаан будаа, шар будаа, гурвалжин будаа, хөц будаа; элсэн чихэр; ургамлын тос, цөцгийн тос, маргарин; ногоон цай; гахай, шувууны мах /шинэ,

хөргөсөн, хөлдөөсөн/, загасны мах /шинэ, хөргөсөн, хөлдөөсөн, хатаасан, давсалсан, утсан/-ны гаалийн тарифын хувь хэмжээг өөрчлөн тогтоох эрхийг Засгийн газарт олгосугай.

2.Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс нь букуу 2008 оны 5 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 03 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 93

Улаанбаатар хот

Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах тухай

Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газраас Иргэний нийгмийн зөвлөлтэй хамтран ажиллах гэрээг зарчмын хувьд дэмжиж, түүнд гарын үсэг зурах эрхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Энхболдод олгосугай.

2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон төсвийн гүйцэтгэлд мониторинг хийх үйл ажиллагаанд төрийн бус байгууллагуудыг оролцуулах нөхцөл бүрдүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж, түүний явц, үр дүнг жил бүрийн I улиралд багтаан Хууль зүй, дотоод хэргийн яаманд ирүүлж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, тогтоолын хэрэгжилтийг улсын хэмжээгээр нэгтгэн, дүнг жил бүрийн II улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Мөнх-Оргилд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.ЭНХБОЛД**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ИРГЭНИЙ НИЙГМИЙН ЗӨВЛӨЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ

Нэг. Нийтлэг үндэслэл

Нэг талаас Монгол Улсын Засгийн газар (цаашид Засгийн газар гэх), нөгөө талаас Иргэний нийгмийн зөвлөл (цаашид Зөвлөл гэх) харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Хоёр. Хамтын ажиллагааны үндсэн чиглэл

2.1. Улс орны тулгамдсан асуудлаар санал солилцох

2.2. Монгол Улсын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих

2.3. Олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах

2.4. Хуулийн төсөл, бодлогын баримт бичиг боловсруулахад хамтран ажиллах

2.5. Монгол Улсын төсвийн гүйцэтгэлд мониторинг хийх

- 2.6. Олон Улсын гэрээ хэлэлцээрийн хэрэгжилтийн талаар санал солилцох
- 2.7. Харилцан мэдээлэл солилцох
- 2.8. Харилцан дэмжлэг үзүүлэх

Гурав. Хамтран ажиллах үндсэн зарчим

- 3.1. Хууль дээдлэх
- 3.2. Харилцан бие биенээ хүндэтгэх
- 3.3. Эрх тэгш байх
- 3.4. Улс төрийн нөлөөллөөс ангид байх
- 3.5. Нээлттэй, ил тод байх

Дөрөв. Засгийн газрын хүлээх үүрэг

Засгийн газар дараахь үүрэг хүлээнэ:

4.1. Иргэний нийгмийн байгууллагуудыг эрх зүйн хүрээнд дэмжих чиглэлээр төрөөс баримтлах бодлогын баримт бичиг болон Төрийн бус байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, Төрийн бус байгууллагад өгсөн хандивыг орлогын албан татвараас чөлөөлөх асуудлын эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар санаачилга гаргах;

4.2. Зөвлөлийн үйл ажиллагаанд өөрийн эрхийн хүрээнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

4.3. Улсын болон орон нутгийн төсвийн гүйцэтгэлд мониторинг хийх асуудлаар төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах;

4.4. Зөвлөлийг холбогдох мэдээллээр хангах;

4.5. Засгийн газрын үйл ажиллагааны талаархи мэдээллийг хагас жил тутам Зөвлөлд хүргүүлж байх;

4.6. Шаардлагатай тохиолдолд Засгийн газрын шугамаар гадаад оронд туршлага судлах үйл ажиллагаанд Зөвлөлийн төлөөллийг оролцуулахад анхаарах;

4.7. Тухайн асуудал эрхэлсэн сайдын зөвлөлийн бүрэлдэхүүнд уг асуудлаар тогтвортой ажиллаж байгаа иргэний нийгмийн байгууллагын зарим төлөөллийг оруулах бололцоог судалж шийдвэрлэх.

Тав. Зөвлөлийн хүлээх үүрэг

Зөвлөл дараахь үүрэг хүлээнэ:

5.1. Зөвлөлийн бүрэлдэхүүнд Төрийн бус байгууллагууд нээлттэй орох, бүрэлдэхүүнд орсон байгууллагууд эрх тэгш харилцах нөхцөлийг хангах, тэдгээрийг нэгдсэн бодлого, удирдамжаар хангах;

5.2. Монгол Улсын төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын бодлого, хөтөлбөр, хууль тогтоомжийн хэрэгжилтэд мониторинг хийх, зөвлөмж гаргах;

5.3. Улс орны тулгамдсан асуудлаар санал гарган Засгийн газарт хүргүүлэх, тухайн асуудлаар ажлын уулзалт зохион байгуулах, Засгийн газраас

тодорхой асуудлаар байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллах;

5.4. Засгийн газрын үйл ажиллагааг иргэдэд хүргэх, таниулах зорилгоор иргэдэд чиглэсэн сургалт, сурталчилгааг Зөвлөлд нэгдсэн байгууллагуудаар дамжуулан зохион байгуулах;

5.5. Зарим асуудлаар Засгийн газартай хамтарч хуулийн төсөл боловсруулах;

5.6. Иргэд болон төрийн бус байгууллагуудын санал санаачилгыг Засгийн газарт уламжлан шийдвэрлүүлэх;

5.7. Засгийн газраас баримталж байгаа бодлогын талаар төрийн бус байгууллагуудад мэдээлэл өгөх;

5.8. Төрийн бус байгууллагуудыг дэмжих асуудлаар бодлогын баримт бичиг боловсруулж Засгийн газарт уламжлах;

5.9. Зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хагас жил тутам Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран гаргах.

Зургаа. Хамтран хүлээх үүрэг

6.1. Хоёр тал гэрээгээр хүлээсэн үүрэгээ ёсчлон биелүүлнэ.

6.2. Гэрээний заалтыг аль нэг тал нь бүрэн биелүүлээгүй тохиолдолд нөгөө тал нь тухайн асуудлаар тайлбар авах бөгөөд биелүүлэхийг шаардана.

6.3. Гэрээг бүхэлд нь буюу түүний заалтад өөрчлөлт оруулах талаар аль нэг тал нь санаачилга гаргасан тохиолдолд хамтран хэлэлцэж шийдвэрлэнэ.

Долоо. Гэрээг цуцлах

7.1. Аль нэг талын буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан гэрээний заалтуудыг зөрчсөн тохиолдолд нөгөө талын санаачилгаар гэрээг цуцлах талаар санаачилга гарган харилцан ярилцаж шийдвэрлэнэ.

Найм. Гэрээ хүчин төгөлдөр болох

8.1. Хоёр тал харилцан тохиролцож гэрээнд гарын үсэг зурснаар гэрээ хүчин төгөлдөр болно.

8.2. Гэрээг 2 хувь монгол хэлээр үйлдэж, хоёр тал хадгална.

Ес. Тайлан хэлэлцэх

9.1. Монгол Улсын Засгийн газар, Иргэний нийгмийн зөвлөлийн хамтын ажиллагааны тайланг хэлэлцэхдээ аль аль талын төлөөлөл байлцуулна.

Гэрээ байгуулсан:

Монгол Улсын Засгийн
газрыг төлөөлж

Иргэний нийгмийн
зөвлөлийг төлөөлж

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2008 оны 05 дугаар сарын 14-ний өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4.3 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим
12 цаг 40 минут

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Бямбадорж даргалж, гишүүдэд Н.Жанцан /илтгэгч/, П.Очирбат, Ж.Болдбаатар, Д.Мөнхгэрэл нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар С.Энхтуулыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд өргөдөл гаргагч Нийслэлийн Баянгол дүүргийн 6 дугаар хорооны оршин суугч, иргэн М.Батсуурь, Ч.Өнөрбаяр, Хан-Уул дүүргийн 1 дүгээр хорооны оршин суугч, иргэн Б.Болд, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн С.Баярцогт нар оролцов.

Хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4.3 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцлээ.

Нэг. Баянгол дүүргийн иргэн М.Батсуурь, Ч.Өнөрбаяр нараас Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан өргөдөлдөө:

"1. Улсын Их Хурлаас 2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийг шинэчлэн найруулж батлахдаа тус хуулийн 27 дугаар зүйлийн 4-т "Нэр дэвшигч нь ... дараахь шаардлагыг хангасан байна" гээд 27.4.3-т "ялгүй байх" гэсэн ойлголтыг тодорхойлсон. Энэнь:

Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан "эрх чөлөө, тэгш байдал нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн", 16 дугаар зүйлд "Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ" гээд 9 дэх хэсэгт "... төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй" гэснийг зөрчиж байна. Учир нь Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4.3-т заасан "ялгүй байх" гэсэн алдатай шинэ томъёолол нь Монгол Улсын дээд шүүхээс 2008 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 16 тоот тогтоолын 12 дахь заалтад "Ялгүй байх гэдгийг

Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлд заасан "ялгүйд тооцох", "ялгүй болох" гэсэн ойлголтуудтай адилтгаж үзэх үндэслэлгүй тул үүнийг өмнө нь огт "ял шийтгүүлж байгаагүй гэнэ" хэмээн буруу тайлбар гарах нөхцлийг бүрдүүлсэн. Энэ нь Монгол Улсын иргэн бүх насаараа ялтай үр дагаварыг бий болгоод зогсохгүй социалист эрүүгийн хуулиар гэмт хэрэг хэмээн үзэж байсан үйлдэл, эс үйлдэхүйг хийж ял шийтгүүлсэн болон эсхүл огт гэмт хэрэг хийгээгүй мөртлөө хилсээр ял шийтгэгдсэний төлөө өнөөдөр Үндсэн хуулиар хамгаалагдсан иргэнийхээ үндсэн эрх, эрх чөлөөг эдэлж чадахгүйд хүрч байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1-т "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүрэгтэй" гэснийг зөрчиж байна. Монгол Улсын Их Хурал нь Үндсэн хуулийн дээрх заалтын дагуу Монгол Улсын иргэн үндсэн эрх, эрх чөлөөгөө саадгүй эдлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх ёстой бөгөөд ингэхдээ Үндсэн хуулийн үзэл баримтлал, гэж хэмжээнд захирагдаж, түүний агуулгаас хамжи болохгүй байдаг. Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагад "сонгогдох" эрхийг зөвхөн хуулиар "нас"-ны хязгаарлалт тогтоохоор зохицуулсан байтал Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулиар нэр дэвшигчид "ялгүй байх" гэсэн Үндсэн хуульд заагаагүй шаардлага тавьснаар Үндсэн хуулийн агуулгаас хальж, иргэнийхээ "сонгогдох эрх"-ийг хасч, тэдний эрх зүйн байдлыг дордуулсан байна.

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4.3 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2, 16 дугаар зүйлийн 9, 19 дүгээр зүйлийн 1-ийг тус тус зөрчсөн болохыг тогтоож өгнө үү" гэжээ.

Хоёр: Хан-Уул дүүргийн иргэн Б.Болд Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн өргөдөлдөө:

" Улсын Их Хурлаас 2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр Монгол Улсын Их Хурлын

Сонгуулийн тухай хуульд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх хэсэгт заагдсан Монгол Улсын иргэний үндсэн эрх болох ... төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй гэсэн, Хорин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын 25 нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно гэсэн заалтуудыг зөрчсөн заалтууд орсон байна гэж үзэж байна. Тухайлбал, Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т Үндсэн хуулийн үзэл санааг илэрхийлсэн сонгогдох эрхийн тухай үндсэн шаардлагыг бүрэн хэмжээгээр тодорхойлсон атлаа мөн хуулийн 27 дугаар зүйлд Үндсэн хуулийн үзэл санаа, хэм хэмжээг зөрчсөн төдийгүй Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хэрэгждэг, тайлбарлагддаг, шаардлагагүй заалт орсон байна.

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4 дэх хэсгийн 27.4.3-т заасныг холбогдох хууль тогтоомжид зохицуулан илүү тодорхой болгох буюу хасах шаардлагатай гэж үзэж байгаа тул дээрх заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн талаар дүгнэлт гаргаж өгнө үү” гэжээ.

Гурав. Улсын Их Хурлын даргын 2008 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 55 дугаар захиралжаар томилогдсон Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Д.Одбаяр, С.Баярцогт нар Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“... Үндсэн хуулиар Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын 25 насанд хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно гэсэн үндсэн шаардлага /болзол/, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар нэр дэвшигч нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон эзэл, батлан даалтын болон бусад гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өргүй байх, шүүхийн шийдвэрээр тогтоогдсон татварын өр төлбөргүй байх, ялгүй байх гэсэн хууль зүйн тусгай шаардлага тус тус тавигдсан... Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулиар нэр дэвшигчид тавигдсан “ялгүй байх” гэсэн шаардлагын тухайд, хууль санаачлагч анх хуулийн төсөлдөө нэр дэвшигч “санаатай үйлдсэн гэмт хэрэгт ял шийтгэгдэж байгаагүй байх” гэсэн шаардлагыг хангасан байхаар тусгасан байсныг Улсын Их Хурлын чуулганы хэлэлцүүлгийн явцад хууль тогтоогч “ялгүй байх” гэж өөрчилсөн, өөрөөр хэлбэл, уг ойлголтод “огт ял шийтгэгдэж байгаагүй”, түүнчлэн “ял шийтгэгдэж байсан боловч Эрүүгийн хуулийн 78.2-т заасны дагуу ялгүй болсон, мөн хуулийн 78.3-т заасны дагуу ялгүйд тооцогдсон байх” ойлголтуудыг багтаасан.

Гэтэл,

1. Улсын дээд шүүх 2008 оны 3 дугаар сарын 31-ний өдөр гаргасан тайлбартаа мөн хуулийн 27 дугаар зүйлийн 27.4.3-т заасан “ялгүй байх” гэдгийг “...үүнийг өмнө нь огт “ял шийтгүүлж байгаагүй” гэж ойлгон хэрэглэнэ” гэж тайлбарласан;

2. Улсын дээд шүүхээс мөн оны 5 дугаар сарын 6-ны өдөр Улсын Их Хурлын даргад ирүүлсэн албан бичигт “Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшигчид “ялгүй байх” шаардлагыг Улсын дээд шүүх тайлбараараа биш харин Улсын Их Хурал хуулиар тогтоосон тул Үндсэн хууль, Сонгуулийн тухай хуулийн бусад заалтад байхгүй энэ шалгуур хүний сонгогдох эрхийг зөрчсөн байх магадлалтай” гэсэн;

3. Улсын дээд шүүхийн энэхүү тайлбар нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн үзэл баримтлал, агуулгатай зөрчилдсөн тайлбар болсон гэж хууль тогтоогч үзэж байгаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2-т “...Улсын дээд шүүхийн тайлбар хуульд харшилбал хуулийг дагаж биелүүлнэ” гэж заасан боловч Улсын дээд шүүхийн дээр дурдсан тайлбар хүчин төгөлдөр байгаа нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд байгаа “ялгүй байх” гэсэн ойлголтыг эрх зүйн цоо шэнэ ойлголт, хэм хэмжээ болгож хууль санаачлагчийн үзэл баримтлалаас өөрөөр хэрэглэх болгож байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 27.4.3 дахь заалт нь өргөдөл гаргагчдын өргөдөлдөө дурдсан “нэр дэвшигчдийн эрх зүйн байдлыг дордуулсан” гэж үзэх үндэслэлийг үгүйсгэхгүй байна” гэжээ.

Дөрөв. “Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” Монгол Улсын Дээд шүүхийн 2008 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 16 дугаар тогтоолд:

“...12. Хуулийн 27 дугаар зүйлийн 27.4.3-т заасан “ялгүй байх” гэдгийг Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлд заасан “ялгүйд тооцох”, “ялгүй болох” гэсэн ойлголтуудтай адилтгаж үзэх үндэслэлгүй тул үүнийг өмнө нь огт “ял шийтгүүлж байгаагүй” гэж ойлгон хэрэглэнэ” гэжээ.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн С.Баярцогт Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаан дээр хэлсэн үгэндээ:

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны хэлэлцүүлгийн явцад УИХ-ын Сонгуулийн тухай

хуулийн 27 дугаар зүйлийн 27.4.3 дахь заалтыг гишүүд ойлгохдоо өмнө нь огт ял шийтгүүлж байгаагүй болон Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлд заасан ял шийтгэлгүй болох, ял шийтгэлгүйд тооцох хугацаа нь дуусгавар болсон хүнийг хамааруулан ойлгосон. Энэ ойлголтоороо санал хураалгаж, уг хууль батлагдсан. Гэвч Улсын дээд шүүхийн тайлбар "ялгүй байх" гэдгийг "өмнө нь огт ял шийтгүүлж байгаагүй хүнийг ойлгоно" гэж гарсан, одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа нь хууль санаачлагчийн үзэл баримтлалаас өөрөөр тайлбарлагдаж, ойлгогдож байгаа тул хуулийн уг заалт Үндсэн хууль зөрчсөн гэдгийг хүлээн зөвшөөрч байна гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулинд буй "Ялгүй байх" гэсэн ойлголт нь уг хуулинд Улсын Дээд шүүхийн хийсэн тайлбар, Үндсэн хуулийн цэцэд өргөдөл гаргагчдын тавьсан үндэслэл болон бусад нотолгооноос үзэхэд өмнө нь огт ял шийтгүүлж байгаагүй гэсэн агуулгыг илэрхийлж байна.

2. Хууль тогтоогч Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулинд нэр дэвшигчид тавих шаардлагад "Ялгүй байх" гэсэн заалтыг оруулснаараа ялгүйд тооцох гэсэн ойлголтоос агуулгын хувьд өөрчлөгдөж Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээдийн улс төрийн эрх буюу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдох эрхийг ял шийтгүүлсний дараа бүх насаар нь хязгаарлаж байгаагаараа Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулсан байна.

Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтуудыг удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ НЬ:

1. Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4-т "Нэр дэвшигч

нь ... дараахь шаардлагыг хангасан байна" гээд 27.4.3-т "ялгүй байх" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх хэсгийн "... төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй", Хорин нэгдүгээр зүйлийн 3-т "Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын хорин таван нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

2. Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4.3 дахь заалт Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-т "... эрх чөлөө, тэгш байдал нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн", Арван есдүгээр зүйлийн 1-д "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүрэгтэй" гэсэн заалтуудыг зөрчөөгүй байна.

3. Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4.3 дахь заалтын "ялгүй байх" гэснийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх заалтыг үндэслэн 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн түтгэлзүүлсүгэй.

4. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор багтаан хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ

Ж.БЯМБАДОРЖ

ГИШҮҮД

Н.ЖАНЦАН

П.ОЧИРБАТ

Ж.БОЛДБААТАР

Д.МОНХГЭРЭЛ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэлэлцэх хэсэгт хэллэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 265956
Индекс 14903

☎ 329487
Хэвлэлийн хуудас 4